



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 342

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.2, 6.2.4, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын ахлах байцаагчийн 2016 оны 07/008/350 тоот дүгнэлт, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагчийн 2019 оны 02-07-092/1145 тоот дүгнэлтээр тус тус тогтоогдсон, нийт 760,859,637.00 (долоон зуун жаран сая найман зуун тавин есөн мянга зургаан зуун гучин долоон) төгрөгийн балансын үнэ, 44,412,950.32 (дөчин дөрвөн сая дөрвөн зуун арван хоёр мянга есөн зуун тавин төгрөг гучин хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Б.Баасандорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Монгол Улсын 2020 оны төсөвт Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бүртгэлийн үйлчилгээний цогцолбор төв байгуулах зардлын төсөв батлагдсаны дараа барилгыг буулгах ажлыг зохион байгуулах;

2.2. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, буулгах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.3. Үл хөдлөх хөрөнгийн газар /чөлөөлөгдөх талбай/-ыг төрийн байгууллагын эзэмшилд хэвээр үлдээж, албан ажлын зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх, газрыг нөхөн сэргээх;

2.4. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙНХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР

0000651

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн
дугаар тогтолцоны хавсралт

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛ ЭЙ,
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, зориулалт, байршил	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуриимтлагдсан элэгдэл (төгрөг)	Үндэгдэл өртөг (төгрөг)
1	Үйлчилгээний 2 дугаар барилга (конторын барилга, архивын фонд, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо)	1970/1990	M2	1,522.81	216,650,513.29	20,633,382.24	196,017,131.05
2	Үйлчилгээний 2 дугаар барилтын өргөтөл (агуулах, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо)	2006	M2	620.00	122,299,016.11	8,153,267.76	114,145,748.35
3	Үйлчилгээний 3 дугаар барилга (конторын барилга, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо)	1970/1985	M2	1091.42	421,910,107.60	15,626,300.32	406,283,807.28
					760,859,637.00 (долгоон зуун жаран сая найман зуун тавин есөн мянга зургаан зуун гучин долоон)	44,412,950.32 (дөчин дөрвөн сая дөрвөн зуун арван хоёр мянга есөн зуун тавин төгрөг гучин хоёр мөнгө)	716,446,686.68 (долгоон зуун арван зургаан сая дөрвөн зуун дөчин зургаан мянга зургаан зуун наян зургаан төгрөг жаран найман мөнгө)
					Нийт дүн		